Mongol - Сүнсний Дайн Оршил Судрууд - SW Intro Scriptures

Лук 17:5 Элч нар Эзэнд — Итгэлийг маань өсгөөч гэхэд
Ром 10:17 Тиймээс итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг.
Лук 11:1 Нэгэн газар Түүнийг залбирч дуусаны дараа шавь нарынх нь нэг Түүнд — Эзэн, Иохан шавь нартаа хэрхэн залбирахыг заасан шиг бидэнд зааж өгөөч гэжээ.
1 Тимот 2:1-4 Тиймд юуны өмнө би гуйя. Гуйлт, залбирал, хүсэлт болон талархлаа бүх хүмүүсийн төлөө үйлд. 2 Хаадын төлөө, эрх мэдлийг баригч бүх хүний төлөө үйлд. Тэгвэл бид бүхий л бурханлаг ба хүндлэлтэйгээр амар тайван, түвшин амьдралаар амьдрах юм. 3 Энэ нь бидний Аврагч Бурханы мэлмийд сайн бөгөөд тааламжтай. 4 Тэрээр бүх хүмүүсийг аврагдаасай, үнэний мэдлэг уруу ирээсэй гэж хүсдэг.
Зэхариа 3:1,2 Дараа нь тэр надад ЭЗЭНий тэнгэр элчийн өмнө зогсож буй тэргүүн тахилч Иошуаг болон түүнийг буруутгахаар баруун гар талд нь зогсож буй Сатаныг үзүүлэв. 2 ЭЗЭН Сатанд — Сатан аа! ЭЗЭН чамайг буруушааж байна. Үнэхээр Иерусалимыг сонгосон ЭЗЭН чамайг буруушааж байна. Энэ бол галаас авагдсан тамга бус уу? гэв.
Ефес 6:12 Учир нь бидний тэмцэл бол махан бие ба цусны эсрэг биш, харин захирагчид, эрх мэдэл, энэхүү харанхуй ертөнцийн хүчнүүд, тэнгэрлэг газар дахь бузар муугийн сүнслэг хүчний эсрэг билээ.
Ефес 6:10,11 Эцэст нь Эзэн дотор ба Түүний чадлын агуу хүч дотор бэхжигтүн. 11 Та нар диаволын зальмэхийн эсрэг бат зогсох чадвартай байхын тулд Бурханы бүрэн хуяг дуулгыг өмс.
Ефес 6:13-17 Тиймээс бүхнийг хийсний дараа, бузар муу өдөрт эсэргүүцэн бат зогсох чадвартай байхын тулд Бурханы бүрэн зэвсгийг ав. 14 Тэгээд бат зогс. Ингэхдээ та нар бэлхүүсээрээ үнэнийг бүсэлж, зөвт байдлын хуягийг өмсөөд, 15 амар тайвны сайн мэдээний бэлэн байдлыг хөлдөө өмс. 16 Энэ бүгд дээр муу нэгний бүх галт сумыг унтрааж чадах итгэлийн бамбай, 17 авралын дуулгыг болон Сүнсний сэлэм буюу Бурханы үгийг ав.
Еврей 4:12 Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхтэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц бөгөөд сэтгэл хийгээд сүнсийг, үе мөч хийгээд нугас чөмгийг салтал нэвтрэн ордог бөгөөд зүрхний бодол хийгээд санааг ч шүүх чадвартай юм.
Лук 4:8 Есүс түүнд — "Чи өөрийн Бурхан Эзэндээ мөргөж, зөвхөн Түүнд үйлчил" гэж бичигдсэн байдаг гэв.
Ефес 6:18 Сүнс дотор цаг үргэлж аливаа залбирал ба гуйлтаараа залбир. Үүний тулд бүх ариун хүмүүсийнтөлөөх цөхрөлтгүй бүх оролдлого,

гуйлтаараа сэргэг бай.

1 Самуел 17:45-47 Давид филист хүнд — Чи идд, бамбай, жад барьж над уруу ирж байгаа бол, харин би чиний доромжилсон Израилийн бүх цэргийн Бурхан, түмэн цэргийн ЭЗЭНий нэрээр чам уруу ирж байна. 46 ӨнөөдөрЭЗЭН чамайг миний гарт өгнө. Би чамайг алаад, чиний толгойг биенээс чинь таслан авна. Өнөөдөр би филист цэргүүдийн хүүрийг огторгуйн шувууд, хээрийн зэрлэг араатанд өгнө. Бүх улс Израильд Бурхан байна гэдгийг мэдэх болно. 47 Энэ цугласан олон ч ЭЗЭН илд, жад хэрэглэлгүй аварна гэдгийг мэдэх буй заа. Энэ тулалдаан бол ЭЗЭНийх бөгөөд ЭЗЭН та нарыг бидний гарт өгнө хэмээв.

Лук 10:17-20 Мөнөөх далан хүн баяртайгаар буцан ирж, — Эзэн, чөтгөрүүд хүртэл Таны нэрээр бидний эрхшээлд орсон шүү хэмээхэд 18 Тэр тэдэнд — Би Сатаныг аянга адил тэнгэрээс буухыг нь харав. 19 Харагтун, Би та нарт могой, хилэнцэт хорхойнуудад хаддах, дайсны хамаг хүчээс дээгүүрх эрх мэдэл өгсөн. Та нарт юу ч хор учруулахгүй. 20 Гэсэн хэдий ч сүнснүүд эрхшээлд чинь орсон гэдэгт та нар бүү баярла, харин нэрс тань тэнгэрт бичигдсэн гэдэгт баярлагтун гэв.

2 Коринт 10:3-5 Учир нь бид махан бие дотор алхдаг боловч, махан биеийн дагуу дайтдаггүй. 4 Учир нь бидний байлдааны зэвсэг бол махан биеийнх биш, харин цайзуудыг эвдэж нураах Бурханы хүчит зэвсгүүд юм. 5 Бид цэцэрхэл болон Бурханы мэдлэгийн эсрэг босогч аливаа өндөрлөг зүйлийг устгаж, ямар ч бодол санааг Христийн дуулгавартай байдалд олзлуулдаг.

Матай 16:19 Би чамд тэнгэрийн хаанчлалын түлхүүрийг өгнө. Чи газар дээр юуг холбоно, тэр нь тэнгэрт холбогдоно. Газар дээр юуг тайлна, тэр нь тэнгэрт тайлагдах болно гэлээ.

2 Тимот 1:7 Учир нь Бурхан бидэнд айдсын сүнсийг бус, харин хүч, хайр ба биеэ захирахын сүнсийг өгсөн.

Матай 12:28,29 Харин хэрвээ Би Бурханы Сүнсээр чөтгөрүүдийг зайлуулдаг бол Бурханы хаанчлал та нарт ирчихээд байна. 29 Бяртай эрийг эхлээд хүлэхгүй бол хэн түүний гэрт нь ороод эд хөрөнгийг нь булааж чадах билээ? Хүлсний дараа л гэрийг нь дээрэмдэнэ шүү дээ.

Ефес 1:13 Түүний дотор та нар ч бас үнэний үгийг буюу та нарын авралын сайн мэдээг сонссоны дараа, мөн Түүнд итгээд, амлалтын Ариун Сүнсээр тамгалагдсан байв.

Үйлс 19:6 Ийнхүү Паул тэдэн дээр гараа тавихад Ариун Сүнс тэдэн дээр ирж, тэд олон хэлээр ярьж, эш үзүүлжээ.

Марк 16:15-18 Есүс тэдэнд — Бүх дэлхийгээр явж, сайн мэдээг бүх бүтээлд тунхаглагтун. 16 Хэн итгэж баптисм хүртэнэ, тэр аврагдах болно. Харин итгээгүй хүн нь яллагдах болно. 17 Итгэгчдэд энэ

тэмдгүүд дагалдана. Миний нэрээр тэд чөтгөрүүдийг зайлуулж, шинэ хэлээр ярина. 18 Тэд могойг барина. Тэд үхүүлэх ямар ч юм уусан, тэр нь тэдэнд хор болохгүй. Өвчтэй хүн дээр тэд гараа тавивал эдгэнэ гэж айлдлаа.

1 Иохан 1:9 Хэрэв бид нүглээ хүлээн зөвшөөрвөл Тэрээр итгэмжит, зөвт бөгөөд бидний нүглийг уучилж, бүх лзөвт бус байдлаас биднийг цэвэрлэнэ.

Египетээс гарсан нь 20:5 Чи тэдэнд мөргөж, тэдэнд үйлчилж болохгүй. Учир нь чиний Бурхан ЭЗЭН Би бол хартай Бурхан бөгөөд Намайг үзэн ядагчдын гурав, дөрөв дэх үеийн хүүхдүүдэд нь хүртэл эцгүүдийнх нь нүглийн шийтгэлийг буулгадаг.

Дуулал 109:17 Тэр бас хараах дуртай байсан бөгөөд тэр нь ч өөрт нь буцан иржээ. Тэр ерөөлд баярлаагүй бөгөөд тэр нь ч түүнээс хол байв.

Шүүгчид 16:16 Тэр өдөр бүр түүнийг үгээрээ дарамтлан зовоосонд, түүний сэтгэл санааг мохоов.

Ефес 4:26 Уурласан ч, нүгэл бүү үйдд. Та нарын уур хилэн дээр нар бүү жаргаг.

Ром 14:12 Тиймээс бидний хүн бүр өөрийнхөө тайланг Бурханд өгөх болно.

1 Иохан 2:23 Хүүг үгүйсгэдэг хэнд ч Эцэг байхгүй. Хүүг хүлээн зөвшөөрдөг нэгэнд нь Эцэг мөн бий.

Иохан 14:6 Есүс — Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч Надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй.

Матай 11:28-30 Эцэж туйлдсан, хүнд дарамт үүрсэн хүмүүс ээ, бүгд Над руу ир. Би та нарт амралтыг өгье. 29 Буулгыг минь өөр дээрээ авч, Надаас суралц. Учир нь Би зүрх сэтгэлдээ дөлгөөн, даруу билээ. Тэгээд Та нар сэтгэлдээ амралтыг олох болно. 30 Миний буулга амархан, Миний ачаа хөнгөн гэв.

2 Коринт 6:2 Учир нь Тэр"Би тааламжтай цагт чамайг сонссон. Авралын өдөрт Би чамд тусалсан" гэж айлддаг. Харагтун, одоо бол "Тааламжтай цаг" байна. Харагтун, одоо бол "Авралын өдөр" байна.

Ром 10:13 Учир нь «Эзэний нэрээр дуудах хэн ч аврагдах болно».

Pastor T. John Franklin
Church of Salvation, Healing, and Deliverance
COS-HAD.org